



Европын Холбоо
санхүүжүүлэв



НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага

Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



2023 ОНЫ УЛИРАЛ II

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ

„МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ „ ТӨСӨЛ

УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Хэрэгжих хугацаа: 2020 2024 Төслийн төсөв: 7,400,000 Евро

Зорилго, зорилт:

Төсөл нь Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөрийг дэмжих ерөнхий зорилгын хүрээнд дараах зорилтууд дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:



БОДЛОГЫГ САЙЖРУУЛАХ ЗАМААР
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДАВХ,
БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЛБАРТ ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН, ҮР
НӨЛӨӨТЭЙ, НОТЛОГООНД СУУРИЛСАН БОДЛОГО, ТӨСВИЙН
УЯЛДААГ ХАНГАХ ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ

Төслийн үр шимийг хүртэгсэд:

Залуучууд

Тариаланчид,
малчид

Алслагдсан орон
нутгийн
залуучууд,
зорилтот
бүлгүүд

Хөгжлийн
бэрхшээлтэй
иргэд

Охид,
эмэгтэйчүүд

Албан бус эдийн
засагт ажиллаж буй
эрэгтэй, эмэгтэй
хүмүүс

Ажилгүй, бүрэн бус
хөдөлмөр эрхэлдэг
хүмүүс, ажил
хайгчид

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

А

Бүрэлдэхүүн хэсэг

Бүрэлдэхүүн хэсэг А:

БОДЛОГО, ТӨСВИЙН УЯЛДААГ ХАНГАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг үр дүнд суурилан арга зүйгээр боловсруулах хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-д дэмжлэг үзүүлэн дараах ажлуудыг хамтран гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг боловсруулан, батлуулах;
- Дунд хугацааны буюу 10 жилийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг (ХЗХ) боловсруулах аргачлалыг боловсруулан, батлуулах;
- Монгол Улсын Хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулан, батлуулах;
- Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг ТХЗ-той уялдуулан боловсруулах;

А. ХҮРЭХ ҮР ДҮН

- Төсвийн төлөвлөлтийг үр дүнгийн мэдээлэлд үндэслэн, стратегич байдлаар боловсруулах
- Үр дүнд суурилсан төсвийн танилцуулга
- Нотолгоонд суурилан төсөв боловсруулах
- ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөв боловсруулах чиглэлээр Сангийн яам (СЯ), салбарын яамдын чадавхыг бэхжүүлэх

- Дорноговь аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах зэрэг болно.

Үр дүнд суурилсан төсөвлөлт:

ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх хүрээнд Сангийн яам (СЯ), Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ); Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт дэмжлэг үзүүлэн дараах сургалтуудыг хамтран зохион байгуулж ажиллаа. Үүнд:

- 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 362 төрийн албан хаагчдыг хамруулсан “Үр дүнд суурилсан удирдлага” сэдэвт бүсчилсэн сургалт;

[Мэдээ үнших холбоос](#)

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны төсөвлөлт, тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 260 гаруй мэргэжилтнүүдийг хамруулсан “Үр дүнд суурилсан удирдлага” сургалт; [Мэдээ үнших холбоос](#)

- Аймаг/дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дарга, албан хаагчид, холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан “Хүүхэд хамгаалал”-ын хөтөлбөрийн төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээ хийх чиглэлд чадавхжуулах сургалт; [Мэдээ үнших холбоос](#)

- Үндэсний аудитын газрын 2024 оны жилийн төлөвлөгөө болон төсөвлөлтийг хамтран боловсруулах хүрээнд холбогдох албан хаагчдыг үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйгээр хангах сургалт, хэлэлцүүлэг;

- Архангай аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус аймаг, сумын албан хаагчдад зориулсан Аймаг/нийслэлийн жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг танилцуулах, чадавхжуулах сургалт;

- Дорноговь, Орхон, Өвөрхангай аймгийн ХХҮГ-ын дарга, мэргэжилтнүүдийг хамруулсан “Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага” сургалт;

- Дорноговь аймагт “Үр дүнд суурилсан төсөв боловсруулах арга зүй” сургалтыг зохион байгуулж орон нутгийн төсвийн төслийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

- ТЕЗ-ийн болон орон нутгийн төсвийн саналыг ТХЗ-той уялдуулан үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулах заавар болон холбогдох маягыг Сангийн яамтай хамтран боловсруулан эцэслэв.

- Орон нутгийн төсвийн Хавсралт 1 маягыг өөрчлөх саналыг боловсруулж Сангийн яамны төсвийн бодлогын газарт хүргүүлэн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Нотолгоонд суурилсан төлөвлөлт, төсөвлөлт:

Нотолгоонд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг дэмжих зорилгоор бодлогын зардал/ өртөг тооцох чиглэлд дараах судалгааны ажлуудыг хийж байна. Үүнд:

- Олон улс дахь сайн туршлагыг судлах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын бодлогод үндэслэн хөтөлбөрийн зардал (бодлогын өртөг) тооцох аргачлалыг судлах;



Европын Холбооноос Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Аксель Никэйз болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Илейн Конкиевич нарын Дундговь аймагт хийсэн албан айлчлал (2023 оны 6 сарын 19-20)

[Видео мэдээтэй танилцах](#)

A

- Соёл, биеийн тамирын салбарт зарлагын шинжилгээ хийх, үр дүнд суурилсан төсвийн саналыг боловсруулахад Соёлын яам болон Биеийн тамир спортын улсын хороонд мэргэжил, аргазүйн дэмжлэгийг үзүүлэн, хамтран ажиллаж байна.

Бүрэлдэхүүн хэсэг В: ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

■ УИХ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх:

- Үр дүнд суурилсан бодлого, төсвийн хяналт, шинжилгээг эрчимжүүлэх хүрээнд УИХ болон байнгын хороодтой хамтран ажиллах 2023 оны төлөвлөгөөг харилцан баталж, холбогдох зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгууллаа.
- УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар, Төсвийн хяналт шинжилгээний хэлтэс, Байнгын хороодын төлөөллийг хамруулсан “Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага” сэдэвт хэлэлцүүлэг, санал солилцох уулзалтуудыг зохион байгууллаа. [Мэдээ унших холбоос](#)
- “Үр дүнд суурилсан бодлого, төсвийн уялдааг хангах” чиглэлээр УИХ-ын гишүүд, Байнгын хороодын дарга, асуудал хариуцсан хэлтсийн албан хаагчдыг оролцуулсан зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, цаашид хамтрах ажиллах ажлын хүрээгээ тодорхойлов.
- УИХ-ын Тамгын газрын Төсвийн байнгын хороонд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг УИХ-ын чуулган, төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэхэд мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлж ажилласан.

Үр дүнд суурилсан тайлагналт:

Үр дүнд суурилсан төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэх журмын төслийг боловсруулан Сангийн яамны төрийн санд хүлээлгэн өгч зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

В: ХҮРЭХ ҮР ДҮН

- Төсвийн хяналтад УИХ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- Төсвийн шинжилгээ, гүйцэтгэлд хяналт тавихад ИНБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх
- Гүйцэтгэлийн аудитыг бэхжүүлж ил тод байдлыг хангах

ИНБ-ын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх:

- ИНБ-ын төсөв боловсруулах үйл явцад оролцох үүргийг тодотгох, нөлөөллийн ажлыг хийх зорилгын хүрээнд 2022 онд төслийн зүгээс дэмжиж ажилласан ИНБ-уудын хийсэн ажлын болоод сургалтын үр дүнд харуулсан богино хэмжээний видео контентыг боловсруулах ажлыг хийж байна.
- ИНБ-ийн үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн үйл явцад хэрхэн оролцох боломжийг харуулсан танилцуулах материалыг бэлтгэн боловсруулах ажлыг сангийн яам болон холбогдох талуудтай зөвлөлдөн гүйцэтгэж байна.

Үндэсний Аудитын Газар:

- Үндэсний аудитын газрын 2024 оны төлөвлөгөө болон төсвийг үр дүнд суурилсан аргачлалаар боловсруулж УИХ-ын төсвийн байнгын хороогоор батлуулахад мэргэжил, аргазүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа.
- Үндэсний аудитын газрын “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” аудитын багт аргазүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.



Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн,
“Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага” хэлэлцүүлэг
(2023 оны 6 дугаар сарын 26-ны өдөр)



Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат,
“Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүй” сургалт
(2023 оны 6 дугаар сарын 9-ны өдөр)

В

Бүрэлдэхүүн хэсэг

Бүрэлдэхүүн хэсэг С: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

■ Хөдөлмөр эрхлэлт

• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг туршин сайжруулах ажлын хүрээнд төслөөс 2022 онд дадлагажих хөтөлбөрийг МоАОЭНХ-той хамтран хэрэгжүүлж улмаар туршилтын арга хэмжээний загвар үр дүнд үндэслэн дагалдан ажилтан бэлтгэх, болон ажил олгогчийг дэмжсэн загвар бүхий шинэ Туршилтын төслийг боловсруулах ажлыг эхлүүлэн, улсын хэмжээнд нийт 1500 орчим ажил олгогч, ААН хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

• Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын албан хаагчдыг “Үр дүнд суурилсан бодлого, төсвийн төлөвлөлт ба иргэн төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хэрэгжүүлэх нь” чиглэлд чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнээс бүрдсэн 160 гаруй албан хаагчдыг хамруулж, нийт 65 сургагч багшийг бэлтгээд байна. Сургагч багш нар нь сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулан иргэн төвтэй хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үр дүнтэй, чанартай үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Түүнчлэн, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан мэргэжилтнүүд сургалтад хамрагдсанаар 2024 оны төсвийн төлөвлөлтийг үр дүнд суурилсан байдлаар боловсруулах чадавхтай болсон.

Мэдээ унших холбоос.

• Монгол Улсад цагийн ажил эрхлэх боломжийн талаар судалгаа хийж, судалгааны тайлангийн үр дүнг ХНХЯ-ны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт танилцуулсан. Судалгааны гол үр дүн дүгнэлт дээр үндэслээд бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал ба цалин хөлсний судалгааг улсын хэмжээнд зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд уг судалгааг төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.



“Энтрепренершип ба бизнес эрхлэх үр чадвар”
хөтөлбөрийн сургалтад шилдэг бүтээлийн тэтгэлэг
авсан багууд (2023 оны 6 сарын 19)



Хөдөлмөр эрхлэлтийн салбарын мэргэжилтнүүдийг
хамруулсан “Үр дүнд суурилсан удирдлага” сургалт
(2023 оны 6 дугаар сарын 5-7)

С.ХҮРЭХ ҮР ДҮН

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдийг сайжруулах, харилцан уялдаатай болгох
- Инновац, гарааны бизнес, бизнес инкубаци, бизнес эрхлэхэд ээлтэй экосистемийг бэхжүүлэх
- Цалинтай болон хувиараа хөдөлмөр эрхлэх чадавх, үр чадварыг нэмэгдүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үр дүнтэй сургамж цуглуулах, улмаар бодлогод тусгах зорилгоор туршилтын төслүүд хэрэгжүүлэх

- МБС-ын чанарын үнэлгээний хүрээ, аргачлалаар мэдээллийг үндэсний түвшинд цуглуулан дүн шинжилгээ хийгдэж байна. 69 сургалтын байгууллага, 138 удирдлага, 246 багш, 2324 сурагч, 309 эцэг, эх, 159 төгсөгч, 249 ажил олгогч үнэлгээнд хамрагдсан ба 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Улаанбаатар хотын 30 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээг суралцагч, багш, сургалтын хөтөлбөр гэсэн 3 үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэн, тайланг БШУЯ-ны цахим хуудсанд байршуулсан.

- ХБИ-д чиглэсэн 3 сургалтын гарын авлагаар 2 ангийн элсэлт авч нийтдээ 29 оюутан анхны төгсөгч болж, нийт төгсөгчдийн 50 гаруй хувь нь ажлын байртай болсон байна.
[Мэдээ үнших холбоос](#)

- Түүнчлэн энтрепренершип сургалтын хөтөлбөрийг 5 сургууль дээр туршиж, туршилтын сургуулиудаас нийтдээ 5 бүтээлийг шалгаруулан тэтгэлэг олгоод байна. [Мэдээ үнших холбоос](#)

- 2023 онд шинэчлэн баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр нөлөөг тодорхойлох аргазүйг боловсруулах, судалгааг зохион байгуулахад оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан.

- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн нэр, индексийн Боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED 2011), Ажил, мэргэжлийн олон улсын стандарт ангилалд (ISCO-08)-д нийцүүлэн МБСБ-ын мэргэжлийн нэр, индексийг шинэчлэхэд БШУЯ-д техник туслалцаа үзүүлж ажиллалаа.



Чадамжийн гэрчилгээ гардуулах Төгсөлтийн арга хэмжээ (2023 оны 6 дугаар сарын 13-ны өдөр)



Өмнөговь аймгийн Даланзадгад хотын оролцогчид

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төслүүд

- "Rural Invest" буюу "Хөдөөгийн хөрөнгө оруулалт" нэртэй бизнес төлөвлөгөө боловсруулахад зориулсан 5 хоногийн иж бүрэн сургалтыг Улаанбаатар хот, Төв аймаг болон Өмнөговь аймгийн Даланзадгад хотод амжилттай зохион байгуулж нийт 102 оролцогч хамрагдлаа. Тус сургалтыг НҮБ-ын ХХААБ-ын Хөрөнгө Оруулалтын төвөөс боловсруулсан бөгөөд жижиг, дунд хөрөнгө оруулалтын төслүүдийг тодорхойлох, боловсруулах, үнэлэх зорилготой цогц хөтөлбөр юм.

С

Бүрэлдэхүүн хэсэг

- ХАА-н салбарт залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдний инновац шингээсэн бүтээгдэхүүн, шийдлийг дэмжих зорилготой “Agripreneurship Challenge” тэмцээнд *шалгарсан* 3 гарааны бизнес компаний бүтээгдэхүүнийг Монголд төдийгүй олон улсын зах зээлд гаргах зорилгоор компани бүрийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан инкубатор хөтөлбөрийг боловсруулж, мэргэжлийн зөвлөхүүд *дэмжин* ажиллаж байна. Инкубатор хөтөлбөрийн хүрээнд компанийн санхүүгийн төлөв байдал болон экспортын бэлэн байдлын үнэлгээг хийж бизнесийн өсөлтийн төлөвлөгөөг боловсрууллаа.


- Ингэний сүүний нэмүү өртгийн сүлжээг төр-хувийн хэвшлийн түншлэлийн загварт суурилан хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлийн хүрээнд ХААИС-ийн Мал Аж Ахуй, Биотехнологийн Сургуультай хамтран “Ингэний эко фермийн тэжээллэгийн менежмент, сүүн ашиг шимийн хэмжээг сайжруулах” судалгааг эхлүүллээ. Гол зорилго нь Өмнөговь аймгийн Ханхонгор, Ханбогд сумдад хагас эрчимжсэн ингэний аж ахуйн зориулсан тэжээлийн норм жор боловсруулж ингэний сүүний найрлага болон гарцыг сайжруулахаар ажиллах юм. Мөн эдгээр сумдад нийт 7,553 тэмээ болон ингэнд эрүүл мэндийн тандалт, үзлэг хийлээ. Тэмээн сүргийн эрүүл мэндийг чанд сахин хамгаалснаар шинээр байгуулагдах хагас эрчимжсэн аж ахуйн ингэний сүүний чанар баталгаажилт, хүнсний аюулгүй байдлыг хангах, экспортын бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэх юм.



Ханхонгор сумд ингэний сүүнээс дээж



Ханбогд сумын тэмээний хаврын бэлчээр



Эрүүл мэндийн тандалт, үзлэг.

- Жил бүрийн 6 дугаар сарын 22-нд Дэлхийн тэмээний өдөр тохиодог бөгөөд 2023 онд энэ өдрийг Монгол Улсад анх удаа тэмдэглэх хүрээнд Ази тивийн сүүний түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гадаад харилцааны яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хамтран Монгол Улсын тэмээний аж ахуй, түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, салбар дундын уялдааг хангах, экспортыг дэмжих, олон талт түншлэлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Монгол Улсын хос бөхт тэмээ-хөгжлийн боломж, стратеги” сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Шадар суурин төлөөлөгч Г.Нямжаргал төслийн хүрээнд хэрэгжүүлж буй зорилтот хөтөлбөрүүдийг танилцуулсан бөгөөд уулзалтын үр дүнд оролцогч талууд [Монгол Улсын хос бөхт тэмээний аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр зөвлөмж](#) гаргалаа.



“Монгол Улсын хос бөхт тэмээ-хөгжлийн боломж, стратеги” зөвлөлдөх уулзалт (2023 оны 6 дугаар сарын 22)

D

Бүрэлдэхүүн хэсэг

Бүрэлдэхүүн хэсэг D: ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

• Хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг 2023 оны 5 дугаар сарын 16-20-нд зохион байгуулав. Тус сургалтаар улсын байцаагчдад хөдөлмөрийн хяналтын талаарх олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээг хэрэгжүүлэх удирдамж, ХНХЯ-ны бодлого, үйл ажиллагаа, шинэчлэн батлагдсан дүрэм, журам, хяналтын хуудас зэргийг танилцуулж, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрхэн төлөвлөх, зохион байгуулах, шинээр боловсруулсан хяналтын хуудсуудыг хэрхэн үйл ажиллагаандаа ашиглах чиглэлээр чадавх бэхжүүлэв. Тус сургалтад ХНХЯ, ХХҮЕГ, НДЕГ болон тэдгээрийн аймаг, нийслэл, дүүргийн салбар байгууллагуудын нийт 130 улсын байцаагч хамрагдав. [Мэдээ унших холбоос](#)

• Хөдөлмөрийн хууль тогтоомжийг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023-2025 онд ХНХЯ, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагаас хэрэгжүүлэх [нарийвчилсан ажлын төлөвлөгөөг](#) төсвийн дэмжлэгээр боловсруулж, гурван талт байгууллагуудаар хэлэлцүүлэн, саналыг тусгаж эцэслэсэн.

• ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тогтолцооны тухай 187 дугаар конвенцын хуулийн нийцлийн судалгааны урьдчилсан үр дүнг танилцуулах, санал авах гурван талт хэлэлцүүлгийг төслийн баг, ХНХЯ-ны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөгжлийн хэлтэстэй хамтран 2023 оны 6 сарын 23-нд зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчооны ХАБЭМ-ийн ахлах мэргэжилтэн Юка Ужита, ХАБЭМ төв, салбарын яамд, МАОЭНХ, МҮЭ-ийн төлөөлөл оролцов. [Мэдээ унших холбоос](#)

D. ХҮРЭХ ҮР ДҮН

- Хууль эрх зүйн орчныг олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээтэй нийцүүлэх
- Хөдөлмөрийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх замаар хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах

• Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн зорилтын хүрээнд төслөөс “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сарын аян”-д идэвхтэй оролцож, уг аяныг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав. Аяны хүрээнд эрүүл, аюулгүй ажиллах эерэг соёлыг олон нийтэд төлөвшүүлэх зорилгоор олон нийтийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх ойлголт, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн уул уурхай, барилга, эрчим хүч, аж үйлдвэр гэх зэрэг эрсдэл өндөртэй салбаруудын ажилчдад чиглэсэн фото челленж, ХАБЭМ-ын талаарх 2 богино хэмжээний видеог хийж олон нийтэд хүргэв. [Мэдээ унших холбоос](#)

• Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан ХАБЭМ-ын сарын аяны хүрээнд ХАБЭМ-ийн үндэсний хоёрдугаар чуулган 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр төрийн ордонд зохион байгуулагдав. Уг чуулганд тус төслийн хүрээнд ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчооны ХАБЭМ-ийн ахлах мэргэжилтэн Юка Ужита “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн орчин үеийн чиг хандлага” сэдвээр мэдээлэл өгч оролцлоо. [Мэдээ унших холбоос](#)





“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сарын аян” фото челленж

- Залуучуудын хөдөлмөрлөх эрх, зохистой хөдөлмөрийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бичил төсөл боловсруулах хакатоныг Залуучуудын зохистой хөдөлмөрийн сүлжээтэй хамтран 2023 оны 6-р сард зохион байгууллаа. Хакатонд нийт 10 багийн 45 залуучууд оролцож хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрх, ХАБЭМ, ногоон ажлын байр, албан бус салбар дахь ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тэгш бус байдал, нийгмийн хамгааллын талаарх ойлголт, мэдлэгээ сайжрууллаа. Баг тус бүрд хөдөлмөрийн харилцаа, жендэрийн тэгш байдал, ХАБЭМ, нийгмийн хамгаалал, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр мэргэшсэн менторууд дэмжлэг үзүүлэн ажилласан. [Мэдээ унших холбоос](#)



1) "Залуучуудын эвлэлдэн нэгдэх, зохистой хөдөлмөрлөх эрхийг МУ-д үйл ажиллагаа явуулдаг франчайз эрхтэй байгууллагад хэрэгжүүлэх нь" төсөл, 2) "Албан бус эдийн засагт ажиллах залуусын ажлын байрны баталгаа нийгмийн хамгааллыг сайжруулах нь" төсөл, 3) "Empowering Girls in Tech" төслүүд шалгарсан.

2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН ТАЙЛАН



Төслийн холбоо барих хаяг

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ

"МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ" ТӨСӨЛ

Монгол Улс, Улаанбаатар 14201

Сүхбаатар дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж - 14

Нэгдсэн Үндэстний байр

Утас: 976-327585